

**САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН ДАРГА, АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ ЦОГТОО ОВОГТОЙ БУЛГАНЧИМЭГ-ИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. "НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ТӨРИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МЭРГЭЖИЛ
АРГА ЗҮЙН УДИРДЛАГААР ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Эхний хагас жил	Хүссэн түвшин /биелэлт/	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
	1	2	3	4	5	6	7
<p>Зорилт 1. "Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль" тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:</p>							
1	Арга хэмжээ № 1.1.1 Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх.	Батлагдсан сангийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар өссөнөөр жигд биелүүлэн ажигласан байх.	Төрийн сангийн дансаар 23672109.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 92.5% -иар биелүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирлаар жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 37.9 тэр бум төгрөгөөр биелүүлсэн байна	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх замаар Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, бааз суурийг нэмэгдүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулан ажиглалаа. Уг ажлаар бусад төрийн байгууллагууд, сумын засаг захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх, нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ажлын байрны хөдөлмөрийн нөхцлөөс хамааран шимтгэл ногдуулах, сайн дурын даатгуулагч малчин, эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй хөдөлмөр эрхлээгүй эцэг /эхчүүд/-н улсын төсөөс хариуцах шимтгэлийг бүрэн авах зэргээр Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлж ажиглалаа. Тайлант хугацаанд сангийн орлогын төлөвлөгөөг оны эхнээс сар бүр 92.7 - 111.9 хувиар жигд ханган биелүүлж ажиглалаа. Тайлант жилийн байдлаар аймгийн төв болон 18 сумын нэгжүүдээр дамжуулан 770 ажил олгогч, 10302 албан журмын даатгуулагч, 7054 сайн дурын даатгуулагчдад хүрч үйлчлэн нийгмийн даатгалын санд 38,433.9 сая төгрөгийн	2024.01.01	2024.12.31

					орлогыг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 101.4 хувиар биелүүлж ажиллах хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.		
					Нийгмийн даатгалын цар хүрээг өргөжүүлэх, нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын засаг захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтран сум тус бүр дээр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаа. Түүнчлэн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас санхүүгийн дэмжлэг авч буй ажил олгогчдыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг хамтран зохион байгуулж ажиллаа. Дээрх ажлын үр дүнд Жаргалант сум 7, Тариат сум 4, Хотонт, Батцэнгэл сум тус бүр 3, Ихтамир, Хангай, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд тус бүр 2, Чулуут, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Төвшрүүлэх, Цахир сум тус бүр 1, Эрдэнэбулган сум 34, нийтдээ аймгийн хэмжээнд 71 ажил олгогч шинээр хамруулж ажиллаа. Үүний үр дүнд нийгмийн даатгалд шимтгэл төлөгч ажил олгогчийн тоог 770-д хүргэлээ. Түүнчлэн албан журмын даатгуулагчийн тоо шинээр 237 – р нэмэгдэж, нийт 10302 –д хүргэж төлөвлөгөө биелүүлж ажиллалаа. Хамрагдалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал ажил олгогчийн тоо 71–р буюу 10.1 хувиар нэмэгдүүлж ажилласан байна.		
3	Арга хэмжээ № 1.1.3 Нийгмийн даатгалын сайн дураар даатгуулагчдын тоог 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, малчдын нийгмийн даатгалын	Шинээр хамруулсан сайн дураар даатгуулагчдын тоог 10-аас доошгүй хувиар, малчдын нийгмийн даатгалын	2023 онд 6413 сайн дурын даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулсан.	Сайн дурын даатгалд 2024 онд 698 даатгуулагч, 470 малчин даатгуулагчийг шинээр хамруулж,	Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2024 оныг "Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил" болгон зарласан ба энэ хүрээнд бид сумын Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж байна. Уг ажлаар төрөөс малчид, эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхчүүдийн нийгмийн баталгааг хангах		
	2. Арга хэмжээ № 1.1.2 Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, сангийн орлогын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдыг шинээр хамруулах ажлыг зохион байгуулах.	Шинээр хамруулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, даатгуулагчдын суурь түвшнээс 9 хувиар нэмэгдүүлсэн байна.	. 2023 онд 699 ажил олгогч, 10486 албан журмын даатгуулагчийг Нийгмийн даатгалд хамруулсан.	2024 онд 26 аж ахуйн нэгж, байгууллагын 125 иргэнийг албан журмын даатгалд шинээр бүртгүүлсэн.		2024. 01.01	2024. 12.31

Хамрагдалтыг 30 хувиар нэмэгдүүлэх доошгүй хувьд хүргэх	Хамрагдалтыг 30 хувиар нэмэгдүүлсэн байна.		Хамраглтын төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Талаар авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийн ач холбогдлыг аймгийн 101 багийн иргэдэд ойлгуулан сурталчилах, арга зүйн зөвлөгөө өгөх, ажлыг орон нутгийн удирдлагуудтай хамтран оны эхнээс зохион байгуулан ажиллагаа. Түүнчлэн тус газраас сумын Засаг дарга, Байцаагчдын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор "Шинээр хамгийн олон малчныг нийгмийн даатгалд хамруулсан сумын Засаг дарга", "Шинээр хамгийн олон ажил олгогч, албан журмын даатгуулагч, сайн дурын даатгуулагч, малчныг хамруулсан сумын нийгмийн даатгалын байцаагч" шалгаруулах болзолт уралдааныг зарлан зохион байгуулж хамраглтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлээ. Мөн төрийн байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдан санхүүгийн дэмжлэг хүссэн иргэд, малчдыг сайн дурын даатгалд хамруулан ажиллагаа. Үүний үр дүнд тайлант хугацаанд сайн дурын даатгалд шинээр 1554 иргэнийг хамруулан хамрагдалтыг 7054 даатгуулагчид хүргэн ажилласан. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр шинээр хамрагдалтын өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар нэмэгдүүлэх ба нийт шинээр хамрагдсан сайн дурын даатгуулагчийн 1034 буюу 76.3 хувь малчин даатгуулагч байна.	2024. 01.01 2024. 12.31
4. Арга хэмжээ № 1.1.4 Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу даатгуулагчдын шимтгэл, алдангийн орлогыг цуглуулах.	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж болон хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах.	Хамтран ажиллах гэрээний заалтыг бүрэн хэрэгжүүлсэн.	Эрүүл мэндийн даатгалын харилцах дансанд цугларсан шимтгэл, алдангийг НДЭГ-ын харилцах	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ систем нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Нийгмийн даатгалын сангуудын дансыг хаах талаар СБГаараас ирсэн чиглэл, зөвлөмжийг хяналтандаа авч биелэлтийг хангаж ажилласан. Энэ хүрээнд ЭМД сангийн Төрийн сан, Төрийн, Хаан, Хас банкнуудад баршиж буй 22 харилцах	2024. 01.01 2024. 12.31

	<p>төвлөрүүлэх, ажлыг шилжүүлэх зохион байгуулах.</p>			<p>дансанд хугацаанд бүрэн шилжүүлсэн байна.</p>	<p>дансны үлдэгдлийг бүрэн төвлөрүүлэх, үлдэгдэлд тооцоо нийлэх зэргээр данс хаах бэлтгэлийн хангах зохион байгуулж ажилласан. Уг ажлаар Нийгмийн даатгалын сангийн 2023 оны 04-р улирлын тайланд эрүүл мэндийн даатгалын сангийн бусад авлага болох төвлөрсөн сангаас авах хүүгийн орлого 546.5 мянган төгрөг, 4 даатгуулагчтай холбоотой 275.5 мянган төгрөгийн нийтдээ 822.0 мянган төгрөг, 1 даатгуулагчтай холбоотой 189.6 мянган төгрөгийн бусад өглөгийг тус тус НЕБ-н актыг үндэслэн бүртгэлд тусгасан. Түүнчлэн 94 даатгуулагчийн 4955.9 мянган төгрөгийн урьдчилж төлсөн ЭМД-н орлогыг орлого шимтгэлийн байцаагчтай тооцоо нийлсэн актаар баталгуужуулан бүртгэлд тусган тайлагнасан. Дээрх бусад авлага, өглөг, урьдчилж төлсөн ЭМД-н шимтгэлийн орлогын жагсаалтыг даатгуулагч болон эзэн холбогдогч бүрээр гарган НДЕГазарт хугацаанд хургуулэн тооцоо нийлж ажилласан. Тайлант хугацаанд ЭМД-н шимтгэлээ төлсөн даатгуулагчийн нийтдээ 21489.6 мянган төгрөгийг бусад өглөгийн дансанд бүртгэн жагсаалтаар баталгаажуулан НДЕГазарт хургуулэн хянуулан ажилласан. Үүний үр дүнд ЭМД-н санд ямар нэгэн өглөг, авлага үүсгэлгүй шилжүүлж ажиллалаа.</p>	<p>2024.01.01</p>	<p>2024.12.31</p>
<p>5.</p>	<p>Арга хэмжээ № 1.1.5 Ажил олгогчоос бусад даатгуулагчийн нийгмийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн тооцооны үлдэгдлийг барагдуулах</p>	<p>Шимтгэлийн өглөг авлагын оны эхний үлдэгдлийг 30-аас доошгүй хувиар бууруулах, нэмж үүсгэхгүй байх арга хэмжээ авч ажиллах. Оны эхний үлдэгдлээс 30-аас доошгүй хувиар бууруулах.</p>	<p>Шимтгэлийн өр авлагыг өмнөх оноос 10 хувиар бууруулан ажигласан.</p>	<p>а) Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн хувьд сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн өглөгийн оны эхний үлдэгдлийг 30-аас доошгүй хувиар барагдуулах, нэмж үүсгэхгүй</p>	<p>2024 онд Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системд шилжин орохтой холбоотойгоор 2023 оны тайлант жилд сайн дурын даатгуулагчдын шимтгэлийн өглөгийг хяналтандаа авч ажилд орсон, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, гэрээний хугацаа дуусгавар болсон, албан журмын даатгалтай болон 0-3 настай хүүхдээ асарч буй эхийн гэрээтэй давхцсан зэргийг үндэслэн нийтдээ 1265 даатгуулагчийн шимтгэл төлөлтийг анхан шатны баримтын бүрдэл, НЕБ-н актыг үндэслэн буцаан олгох зэргээр сайн дурын</p>	<p>2024.01.01</p>	<p>2024.12.31</p>

				Байх, тайлант хугацаанд үүссэн өглөгийг малчин болон бусад даатгуулагчаар тооцоог хийж, баталгаажуулж байх.	даатгуулагчийн шимтгэлийн өглөгийг бууруулах ажлыг хийж сайн дурын даатгуулагчийн өглөг авлагын тайлан дээрх даатгуулагчийн тооцоог 0 үлдэгдэлтэйгээр гарсан. Үүний үр дүнд сайн дурын даатгалд цаашид хамрагдах болон гэрээний хугацаатай байгаа 3780 даатгуулагчийн 131,912.9 сая төгрөгийн урьдчилж төлсөн шимтгэлийн орлогыг сумын байцаагчидтай даатгуулагч нэг бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлагнасныг SICOS системд эхний үлдэгдлээр бүртгэгдсэн. Харин энэ оны тайлант хугацаанд сайн дурын даатгуулагчдад цахимаар гэрээ илгээх, төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг сурталчлах, гэрээг тухай бүр баталгаажуулах, шимтгэл төлөлтийг өдөрөт нь бүртгэх талаар мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч үр дүнг тооцон ажигласан. Үүний үр дүнд SICOS системд 7054-д даатгуулагчийн шимтгэл төлөгт, ногдуулалтыг тооцоо хийгдсэн байна.		
6.	Арга хэмжээ № 1.1.6 Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын бусад өр, авлагыг барагдуулах.	Баталгаажсан өр, авлагын оны эхний үлдэгдлээс 30-аас доошгүй хувиар бууруулсан байх.	Өр авлагыг бууруулах ажлыг эрчимжүүлэн ажигласан.	а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг 30 – аас доош хувиар барагдуулах. б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг барагдуулах, нэмж үүсгэхгүй байх	а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр авлагыг, Нягтлан бодох бүртгэлийн актыг холбогдох байцаагчаар үйлдүүлэн анхан шатны баримтын үндэслэлийг шалгасны үндсэн дээр бүртгэлд тусган, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиглаж хэвшсэн. Түүнчлэн 2019-2023 оны НДЕГаараас хийгдсэн төлөвлөгөөт болон хэлтсийн дотоод хяналт шалгалтын хүрээнд үүссэн 2024 оны бусад авлагын эхний үлдэгдэл 835.7 сая төгрөгөөс 186.9 сая төгрөгөөр буюу 22.3 хувиар бууруулан актын төлбөр зөрчлийг барагдуулсан байна. Бусад өглөгийн тухайд оны эхний үлдэгдэл 6.8 сая төгрөгийг бүрэн буюу 100.0 хувь бууруулан нягтлан бодох бүртгэлд тусган нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын гүйцэтгэлийн сарын мэдээгээр тайлагнан ажиглалаа.	2024.01.01	2024.12.31

					6) НДЕГазарын даргын 2024 оны а/03 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын байгууллагын урсгал үйл ажиллагааны сар, улирлын хуваарь" –ийг мөрдөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж ажиллалаа. Энэ хүрээнд дээрх төсвийн зардлын сарын хуваарилалтад өөрчлөлт оруулах саналыг НДЕГазарт хүргүүлэн гэрэл цахилгааны зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал, томилолт, урсгал засварын зардлыг төсвийг шийдвэрлүүлж ажилласнаар өр, авлага үүсгэлгүй ажиллалаа. Тайлант онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/34, А/47, А/67, А/100, А/129, А/153, А/201 дугаараар тушаалаар байгууллагын урсгал үйл ажиллагааны төсвийн сар улирлын хуваарьт өөрчлөлт орж нийт төсөв 1641.4 сая төгрөг болсон. Дэрэх батлагдсан төсвийн хуваарийн дагуу үйл ажиллагаагаа холбогдох хууль дүрэм журмын хүрээнд зохион байгуулж ажиллалаа. Ингэснээр Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасны дагуу иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, зарчмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллаа.		
7.	Арга хэмжээ № 1.1.7 Нийгмийн даатгалын сангийн орлогыг төвлөрүүлэх.	Нийгмийн даатгалын сангийн орлогыг төв санд бүрэн төвлөрүүлэх.	Жигд хуваарилан ажилласан	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг өдөр бүр төвлөрүүлэх.	Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн системийн шинэчлэлтийн хүрээнд нийгмийн даатгалын сангийн 164 харилцах данснаас сумдын харилцах 144 болон аймгийн эрүүл мэндийн даатгалын 4 нийтдээ 148 дансуудыг хааж зөвхөн аймгийн төвийн Төрийн сан, Хаан, Голомт, Төрийн банкуудад байршиж буй 16 харилцах дансаар дамжуулан нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тооцоог олгох үйл ажиллагааг явуулж байна. Оны эхнээс дээрх банкуудад байршин буй нийт 3 төвлөрсөн орлогын харилцах дансанд ажил олгогч болон даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг	2024.01.01	2024.12.31

					<p>төвлөрүүлэхийг сурталчлан, заавар зөвлөгөө өгч ажилласан. Энэ хүрээнд 770 ажил олгогч, 10302 заавал даатгуулагч, 7054-д сайн дурын даатгуулагчийн нийтлээ 38,433.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллаа. 2024 оны арилжааны банкуудтай байгуулах гэрээ баталгаажиж ирэх хүртэл хугацаанд өдөр бүрийн төвлөрсөн орлогыг НДЕГ-аарын төв санд бүрэн төвлөрүүлэн ажилласан. Харин 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн үлдэгдэл төвлөрүүлэх ажил дээрх гэрээний заалтаар хэрэгжиж эхлэсэн бөгөөд төрийн сангийн орлогыг цахим системээр 41 удаагийн мөнгөн гүйлгээгээр 29,985.1 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан. Ингэснээр НДЕГ-аарын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"–ын 3 –р зүйлийн 3.3 дахь заалтын хэрэгжилтийг бүрэн ханган ажиллалаа.</p>	2024.01.01	2024.12.31
8	<p>Арга хэмжээ № 1.1.8 Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.</p>	<p>Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээг үзүүлсэн байх.</p>	<p>Хууль тогтоомжийг мөрдөж ажилласан</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн 52.2 тэрбум төгрөгийг төлөвлөгөөний дагуу зарцуулна.</p>	<p>Нийгмийн даатгалын 4 сангаас давхардсан тоогоор өнөөдрийн байдлаар нийт давхардсан тоогоор 19850 тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээ авагчдад 135,321.8 сая төгрөгийн зарцуулалт гарсан бөгөөд үүнээс тэтгэврийн даатгалын сангаас нийт 16932 тэтгэвэр авагчдад 129,216.7 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас нийт 2528 даатгуулагчид 4,962.7 сая төгрөг, УОМШӨ-ний даатгалын сангаас 23 тэтгэвэр, тэтгэмж авагчдад 156.3 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 367 даатгуулагчдад ажилгүйдлийн тэтгэмжид 986.1 сая төгрөг олгосон байна. Үүний үр дүнд НДЕГ-н даргын 2023 оны А/80 тоот тушаалаар батлагдсан төсвийн хүрээнд 138,853.3 сая төгрөг зарцуулахаас 135,321.8 сая төгрөг зарцуулж 3,531.5 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллах хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна</p>	2024.01.01	2024.12.31

9	<p>Арга хэмжээ № 1.1.9 Баглагдсан төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах.</p>	<p>Баглагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулаагүй байна.</p> <p>Ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажилласан байна. Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар Тогтоолыг хэрэгжүүлж, орон тоо, хөрөнгө бэлтгэх, шатахуун болон урсгал засварын зардлыг хэмнэсэн байх.</p>	<p>Баглагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж 110 сая төгрөгийн төсвийг хэмнэж ажилласан.</p>	<p>а) Баглагдсан 727.5 сая төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах, зарцуулалтанд хяналт тавих, зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэхгүй байх. б) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгэхгүй ажиллах</p>	<p>а) Байгууллагын үйл ажиллагааны төсвийн тухайд жилийн байдлаар батлагдсан 1641.4 сая төгрөгийн төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулж ажиллаа. Үүнээс ажиллагсадтай холбоотой зардалд 1551.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 38.8 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 18.6 сая төгрөг, бусад урсгал зардалд 22.5 сая төгрөг нийт 1631.4 сая төгрөгийн төсвийг зарцуулж, батлагдсан төсвийг зардлын сар улирлын хуваарийн дагуу ангилаг, бүлэг хооронд шилжүүлэггүй зарцуулан ажиллалаа. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасны дагуу иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, зарчмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллалаа. б) Тус Нийгмийн даатгалын газар нь 2024 оны 01 сарын 01-нээс Монгол улсын засгийн газрын 240, 241 тогтоол, 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82, 83, 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дүгээр тогтоолуудыг хяналтандаа авч 2024 оны 4 дүгээр сарын 1-нээс шинэчлэн тогтоож, батлагдсан төсөвтөө багтаан ажиллагсдынхаа цалинг олгож, өр авлага үүсгэлгүй ажиллалаа. Түүнчлэн төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй 5 жил ажилласан нийт 21 албан хаагчдад 139.4 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшууллыг, Засаг даргын 2024 оны Б/18 тоот захирамжаар зэрэг дэв олгосон 7 ажилтны зэргийн нэмэгдлийг нэмэгдүүлэн олгож ажиллаа. Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэлд 1,389.9 сая төгрөг батлагдсан нь нийт төсвийн 84.7 хувийг эзэлж байна. Үүнээс үндсэн цалинд 696.1 сая төгрөг,</p>	2024.01.01	2024.12.31
---	---	--	---	---	--	------------	------------

					<p>нэмэгдэл цалинд 321.5 сая төгрөг, унаа хоолны хөнгөлөлт 68.6 урамшуулалт цалинд 149.4 сая төгрөг, Ажил олгогчоос хариуцсан төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 154.3 сая төгрөгийг олгон, өр авлага үүсгэлгүй ажиллах ажиллах хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.</p> <p>а) 2023 оны төсвийн жилд 84875 ажил гүйлгээгээр 228,123.6 сая.төгрөгийн орлогын, 227,328.5 сая.төгрөгийн зарлагын гүйлгээг бүрэн зөв бүртгэн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тусган тайлагнасан. Уг тайланг аудитаар шалгуулан "Өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэн ба дүгнэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн, газрын ажилтнуудад танилцуулан shlejdans.mn, ил тод байдлын мэдээллийн самбарт тус тус байршуулан ажилласан.</p> <p>б) Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн санхүүгийн 2023 оны 04-р улирлын тайлант хуулийн хугацаанд аудит хүргүүлэн ажилласан. Төрийн аудитын байгууллагаас сангийн нэгтгэсэн тайланг хянаад "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгч баталгаажуулсан. Харин Аудитын тайлангаар байгууллагын үйл ажиллагааны зардалтай холбоотой 2 албан шаардлагаар үүрэг даалгавар өгсөн. Үүний хүрээнд чиг үүрэг давхардсан орон тоонд ажиллаж байсан албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгож, батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулан албан шаардлагын биелэлтийг 100 хувь ханган ажилласан. Уг биелэлтийн тайланг газрын даргын 2024 оны 01/405 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт хугацаанд нь хүргүүлэн ажиглаа. Төрийн аудитын газрын цахим системд биелэлтийг нотлох баримтын хамтаар байршуулан мэдээлгэсэн болно.</p>	2024.01.01	2024.12.31
10	<p>Арга хэмжээ № 1.1.10 Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, жилийн эцсийн тайланд аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлт авах</p>	<p>Зөрчилгүй дүгнэлт авч, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байх.</p>	<p>2023 онд 2022 оны ТТТайланд Зөрчилгүй дүгнэлт авч ажилласан.</p>	<p>А) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авах. Б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн зарлуулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлнэ.</p>			

Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

ХОЁР. “ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГАХ, ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХЗОРИЛТЫН ХҮРЭЭНД” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөшөлбөр, арга хэмжээ:

<p>1</p>	<p>Арга хэмжээ № 2.1.1 Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж оны үлдэгдлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх.</p>	<p>Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг бууруулна.</p>	<p>Авлагыг бууруулж ажигласан</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн авлага оны эхнээс 40 хувиар буурсан.</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн системийн шинэчлэлт, нэвтрүүлэлтийг хэрэгжүүлэн ажиглаж тайлант онд НДШ-н авлагыг барагдуулах талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч эрчимжүүлж ажиглалаа. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/64, А/162 дугаар тус тус тушаалыг хяналтандаа авч “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах чиглэлээр 2024 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-ний биелэлтийг ханган ажиглалаа. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/64, А/162 дугаарт тус тус тушаалуудыг хяналтандаа авч “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах чиглэлээр 2024 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-ний биелэлтийг ханган ажиглалаа. Уг ажлын хүрээнд сумдад 770 ажил олгогч байгууллагын дарга, захирал, эрхлэгч, нягтлан бодогч нарт шимтгэлээ хугацаандаа төлөх талаарх сануулсан заавар зөвлөгөөг, 8 ажил олгогчдод улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэх, 41 ажил олгогчдын арилжааны банкны харилцах дансны зарлагын гүйлгээг зогсоох, 23 ажил олгогчдод мэдэгдэл, 4 байгууллагыг шүүхийн байгууллагад шилжүүлэн, ажил олгогч, даатгуулагчдад зориулсан мэргэжил арга зүйн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулж ажиглаа. Түүнчлэн аймгийн Засаг дарга, Иргэдийн хурал, боловсрол, эрүүл мэндийн болон аймгийн Прокурорын байгууллагуудтай нийгмийн даатгалын</p>	<p>2024.01.01</p>	<p>2024.12.31</p>
----------	--	---	-----------------------------------	--	---	-------------------	-------------------

					Шимтгэлийн авлагыг барагдуулах талаар хамтран ажиллаа. Үүний үр дүнд 900.9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 70.0 сая төгрөгт хүргэж, 92.2 хувиар бууруулан, НДШ-н орлогод эзлэх авлага 0.2 хувьтай гарах хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.		
2	Арга хэмжээ № 2.1.2 Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг цаг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх	Байцаагч ажилтнуудын хариуцлага өсч, мэдээллийн сангийн мэдээлэл үнэн баталгаатай бүртгэгдсэн байх.	Мэдээллийн санд даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв оруулах тал дээр арга зүйгээр хангаж ажилласан.	а) Шинэчилсэн систем нэвтрүүлэхтэй холбогдуулан даатгуулагчийн мэдээлэл бүрэн болсон байна. б) Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэх ажлыг зохион байгуулна.	а) Монгол улсын Засгийн газрын 2023 оны 471 –р тогтоолоор батлагдсан " Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам ", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын А/44, А/40 тоот "Маягтын загвар, аргачлал батлах тухай " хамтарсан тушаал, ХНХ-н сайдын 2023 оны А/199 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийг тайлалнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам", НДЕГ-аарын даргын 2024 оны а/43 тоот " Даатгуулагчийн төрөл, кодыг нэмж батлах тухай " тушаал зэргийг тус тус хяналтандаа авч ажиллаа. Энэ хүрээнд дээрх тушаал шийдвэрүүдийг байцаагч ажилтнууд болон ажил олгогч даатгуулагч нарт тайлбарлан таниулах, үйл ажиллагаандаа нэг мөр хэрэгжүүлэх талаарх мэргэжил арга зүйн зөвлөгөөг танхим болон цахимаар өгөх сургалтуудыг тасралтгүйгээр зохион байгуулж ажиллалаа. Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санд 770 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаар 10302 гаруй даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, даатгуулагчийн төрөл, код, шимтгэл ногдуулалтыг бүртгэж, түүнийг хянаж ажиллаа. Дээрх ажлуудын үр дүнд даатгуулагчийн төрөлд кодыг зөв сонгон шимтгэлийг үнэн зөв ногдуулах,	2024.01.01	2024.12.31

					тайлангах талаарх ажил олгогчийн мэдлэг дээшилсэн. б) Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хянуулан ажилласнаар 2023 оны мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэх ажлыг зохион байгуулан ажилласан.		
3	Арга хэмжээ № 2.1.3 Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх.	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэчилсэн цолц (Core) системийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	Бэлтгэл ажлыг бүрэн хангах	-	Нийгмийн даатгалын байгууллага нь 44 орон тоотойгоор ажилладаг ба 31 нь нягтлан бодох бүртгэл хөтөлж ажилладаг санхүүгийн ажилтан, байцаагчид байна. Мэдээллийн шинэчилсэн CORE системд дээрх албан хаагчдын нэвтрэх эрхийг олгож нягтлан бодох бүртгэлийг хөтөлж ажлыг эхлүүлсэн. Тайланг хугацаанд НДЕГ-аараас шинэ системтэй холбоотой өгч буй сургалтуудад тухай бүр нь хамрагдах, бүртгэл мэдээлэлтэй холбоотой арга зүйн зөвлөгөө авч ажилласан. Үүний үр дүнд байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгох, шимтгэлийн орлогыг бүртгэх, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг баталгаажуулах бүртгэлийг хөтөлж нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн санхүүгийн 2024 оны 02-р улирлын тайлан хугацаандаа гарган ажилласан.	2024.01.01	2024.12.31
4	Арга хэмжээ 2.1.4 Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, НДЕГ-т ирүүлэх	НДҮЗ-ийн 2010 оны 25 дугаар тогтоолоор “НДС-баталсан тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай хамтран ажиллах журам”-д нийцсэн байна.	Арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээний заалтын хэрэгжилт бүрэн хэрэгжсэн. Дүгнэлтийг НДЕГ-азарт хүргүүлэн ажилласан.	а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. Б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлэх	НДЕГ-аарын даргын 2024 оны 04 сарын 16-нд ирүүлсэн Арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээнүүдийг хяналтандаа авч байгааг ажигтнуудад танилцуулан биелэлтийг хангаж ажиллагаа. Тус ажлын хүрээнд ХААН, Голомт, Төрийн банкуудтай хамтран гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд сар бүрийн 01-ний өдрийн өмнөх ажлын өдөр тэтгэвэр олголтын файлыг бэлдэн банкуудад хүргүүлэн ажиллахын зэрэгцээ Нийгмийн даатгалын ерөнхий газраас сар бүр тэтгэвэр олгох хуваарьт өдрүүдэд файлыг	2024.01.01	2024.12.31

					<p>жагсаалтад ороогүй шинээр тогтоогдсон тэтгэвэр, нас барсаны дараа сарын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа алдсаны хувь, хугацаа сунгасан тэтгэврийн олголт долоо хоногт нэг удаа жагсаалтаар олгож ажиллаа. Түүнчлэн улсын байцаагчийн актын дагуу суутгал хийж буй 100-д тэтгэвэр авагчийн тэтгэврүүд, шүүхийн шийдвэрийн дагуу 50 хувийн суутгал хийж буй тэтгэвэр зэргүүдийг гэрээний дагуу жагсаалтаар олгож ажиллаж байна.</p> <p>Б)Банкуудтай байгуулсан гэрээний биелэлтийг гэрээнд заасны дагуу заалт тус бүрээр ирэх оны 01 сарын эхний 7 хоногт багтаан дүгнэх ба одоогоор гэрээний биелэлттэй холбоотой зөрчил, дуугадал гараагүй байна</p>		
--	--	--	--	--	--	--	--

Гурав. ГУРАВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1	<p>Арга хэмжээ 2.3.1 Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүнтэй уялдан гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах.</p>	<p>1.Төрийн албаны хууль хэрэгжсэн байх</p> <p>2. Хөдөлмөрийн тухай хууль хэрэгжсэн байнх</p> <p>Ёс зүйн зөрчил гаргаагүй байна.</p>	<p>1.Төрийн албаны хууль хэрэгжсэн байх</p> <p>2. Хөдөлмөрийн тухай хууль хэрэгжсэн байнх</p> <p>Ёс зүйн зөрчил гаргаагүй байна.</p>	<p>Төрийн албан хаагчийн ес зүйн хэм хэмжээг чанд сахих, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай болсон байна.</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг нийгмийн даатгалын хуулиас гадна Төрийн албаны хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэл, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг мөрдөн аливаа зардлын гүйцэтгэл, орлого ногдуулалтын бүртгэлийг гүйцэтгэн хянан ажиллаж байна. Түүнчлэн даатгуулагч болон ажигчдад олгож буй тэтгэвэр тэтгэмж, цалин урамшуулал, тогтмол болон бусад зардлын гүйцэтгэлийг Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагааны мэдээллийг шилэн данс цахим хуудас, төрийн байгууллагын ил тод нээлттэй самбарт цаг хугацаанд нь байршуулж ажилласан. Түүнчлэн аймгийн Засаг даргын тамгын газарт байгууллагын</p>	<p>2024.01.01</p>	<p>2024.12.31</p>
---	--	--	--	--	---	-------------------	-------------------

					<p>санхүүгийн болон ХО-н ил тод байдлын тайлангийн биелэлтийг хагас, бүтэн жил гаргаж хургуулсан. Үүний үр дүнд батлагдсан төсвийн хүрээнд сангийн орлогыг бүрдүүлэх, тэтгэвэр тэтгэмж төлбөрийг хуулийн хугацаанд олгож төсвийн гүйцэтгэлийг ханган ажиллаа. Албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухайн хууль, нийгмийн даатгалын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан аливаа зөрчил гаргаагүй болно.</p>		
2	<p>Арга хэмжээ 2.3.2 ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хургуулэх;</p>	<p>Төрийн албаны тухай хууль хэрэгжсэн байх</p>	<p>Хууль дүрэм журмыг мөрдөж ажилласан.</p>	<p>Гүйцэтгэлийн тайланг сар, улирал, хагас жилээр, аймгийн ЭД-ын албан даалгаврын биелэлтийг хагас жилээр гарган, тайлагнасан байх</p>	<p>Тайлант жилд удирдлагаас өгсөн мэрэгжил арга зүйн зөвөлгөө, үүрэг даалгаврын дагуу санхүү бүртгэл, хамралт орлогын хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогчийн АТТ-д заасан ажлаас гадна газрын даргын НДЕГ-аар, аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний өөрийн хариуцсан хэлтэстэй холбоотой заалтуудыг хяналтандаа авах, ТАХ-н гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шинээр тусган биелэлтийг хангах ажлыг жилийн турш зохион байгууллаа. Энэ хүрээнд газрын даргын А/29, А/30 дугаар тушаалаар томилогдсон ажлын ахлагчаар томилогдон баг хамт олноо удирдлага арга зүйгээр ханган ажиллан дараах албан бичгүүдэд тусгасан ажлаа гүйцэтгэн хугацаандаа чанартай тайлагнасан. Үүнд: Хэлтсийн даргын НДЕГ-азартай болон аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө , хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ЗГ-н 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөр, Засгийн газрын гишүүний 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнүүдэд санхүү бүртгэлийн тасгийн үйл ажиллагаатай холбоотой</p>	<p>2024.01.01</p>	<p>2024.12.31</p>

					заалтуудын биелэлтийг хагас бүтэн жилээр гарган тайлагнасан. Түүнчлэн Аймгийн засаг даргын албан даалгаврууд, байгууллагын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүд, хэлстийн даргатай байгуулсан гүйцэтгэлийг төлөвлөгөөний хугацаандаа гаргаж тайлагнан ажиллаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, аян, Хамралтыг нэмэгдүүлэх уралдааны тус тус тайлан, үр дүнг гаргаж хүргүүлэн ажиллаа.		
	Арга хэмжээ 2.3.3 Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хууль хэрэгжсэн байна.	Хууль дүрэм журмыг мөрдөж ажилласан.	Зөрчил дутагдал гаргаагүй байна.	Тайлант жилд ажил олгогч 51 байгууллагаас нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, тайлагналд залруула хийлгэхтэй холбоотой ирүүлснийг Зөрчлийн хэрэг нээх, ажиллагаагаа явуулахаар НДШ-н хяналт шалгалтын байцаагчид шилжүүлж ажилласан. Түүнчлэн шинэ системд Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд залруула хийх болон Улсын байцаагчийн актаар тогтоогдсон төлбөр, зөрчлийг бүртгэх тухай НДЕГ-аараас 2024 оны 12 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсан сургалтад хамрагдан заавар зөвлөгөө авч ажилласан бөгөөд дээрх ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд залруулга хийх ажлыг эрчимжүүлж байна.	2024.01.01	2024.12.31
3							
4	Арга хэмжээ 2.3.4 Өөрийн хариуцсан ажлын ажлын хүрвэн дэх УИХ, ЗГ, НХХЯ, НДЕГ, АИТХ, АЗД, ЗДТГ азар зэрэг дээд шатны байгууллагаас ирүүлсэн тогтоол	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Хууль дүрэм журмыг мөрдөж ажилласан.	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдан тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын багц хуулийн болон нийгмийн даатгалын мэдээллийн системийн хэрэгжүүлэлт, шинэчлэлтэй холбоотой засгийн газрын, ХНХЯ-ны сайд, НДЕГ-аарын даргын гаргасан тогтоол, журам, тушаалуудыг тус тус мөрдөн ажиллах, тэдгээрийг ажил олгогч, даатгуулагчдад сурталчлан таниулах, мэргэжил аргагүйн зөвлөгөөг өгөх ажлыг	2024.01.01	2024.12.31

<p>шийдвэрийг хяналтандаа авч биелэлтийг ханган ажиллах</p>							<p>оны эхнээс цахимаар болон танхимаар тасралтгүй хүргэн, цаашлаад ажлын байран дээр хүрч тайлбарлан таниулах сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Үүний үр дүнд 770 ажил ологчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, 7054 сайн дурын даатгуулагчийн гэрээ баталгаажуулах, 4895 тэтгэвэр, тэтгэмжийн хүсэлтийг цахимаар авч тогтоох, 19815 даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж олгосон ажил гүйлгээг мэдээллийн сангийн шинэ системд бүртгэх үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаа. Энэ хүрээнд нийгмийн даатгалын сангийн орлогыг өдөр бүр шинэ системд бүрэн таниулж хэвшсэн. Түүнчлэн Монгол улсын Засгийн газрын 2023 оны 471 –р тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын А/44, А40 тоот “Маягтын загвар, аргачлал батлах тухай” хамтарсан тушаал, ХНХ-н сайдын 2023 оны А/199 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”, НДЕГ-аарын даргын 2024 оны а/43 тоот “Даатгуулагчийн төрөл, кодыг нэмж батлах тухай” тушаал зэргийг тус тус хяналтандаа авч ажиллаа. Энэ хүрээнд дээрх тушаал шийдвэрүүдийг байцаагч ажилтнууд болон ажил олгогч даатгуулагч нарт тайлбарлан таниулах, үйл ажиллагаандаа нэг мөр хэрэгжүүлэх талаарх мэргэжил арга зүйн зөвлөгөөг танхим болон цахимаар өгөх сургалтуудыг тасралтгүйгээр зохион байгуулж ажиллалаа. Нийгмийн даатгалын нэгдсэн</p>			
---	--	--	--	--	--	--	--	--	--	--

					мэдээллийн санд 770 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаар 10302 гаруй даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, даатгуулагчийн төрөл, код, шимтгэл ногдуулалтыг бүртгэж, түүнийг хянаж ажиллаа. Дээрх ажлуудын үр дүнд даатгуулагчийн төрөлд кодыг зөв сонгон шимтгэлийг үнэн зөв ногдуулах, тайлангах талаарх ажил олгогчийн мэдлэг дээшилж дээрх тогтоолыг шийдвэрийн биелэлтийг ханган ажиллаа.		
5	Арга хэмжээ 2.3.5 Архив, албан хэрэг хөтгөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,	Хууль тогтоомжууд хэрэгжсэн байх.	Хууль дүрэм журмыг мөрдөж ажилласан..	Баримт бичиг боловсруулах журам, баримт бичгийн хяналтын журам, архивын үйл ажиллагааны журам, архив бичиг хэргийн стандарт хэрэгжсэн байна.	Тайлант хугацаанд 51 ажил орлогч, 26 иргэнээс нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, тайлагнал, регистрийн дугаар өөрчлөгдсөн, мэдээллийн санд даатгуулагчийн нэр, регистр зөрүүтэй мэдээллэгдсэн, данс ташааруулсан, давхар даатгуулсан зэрэг ирүүлсэн албан хүсэлт, өргөдлийг шийдвэрлэн ажиллаа. Уг ажлыг ажил олгогч, даатгуулагчаас ирсэн өргөдөл, хүсэлтийг шимтгэлийн хяналт шалгалтын байцаагч, сүлжээ хариуцсан мэрэгжилтэн, тэтгэврийн зөвөлгөө өгөх байцаагч, орлого шимтгэлийн байцаагч, сангийн нягтлан бодогч нартаа уялдаа холбоотойгоор Нийгмийн даатгалын багц хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журмуудын дагуу шийдвэрлэн ажилласан. Дээрх 26 өргөдөл хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн тэдгээр даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээллээ авах, тэтгэвэр тэтгэмж тогтоолгох боломж бүрдсэн. Үүний үр дүнд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаа.	2024.01.01	2024.12.31

6	<p>Арга хэмжээ 2.3.6 Авлигын зэрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.</p>	Хууль тогтоомжууд хэрэгжсэн байх.	Ямар нэгэн зөрчил гаргаагүй ажилласан..	Хууль хэрэгжсэн байна.	<p>Авлигатай тэмцэх газар болон НДЕГ-гаар хамтран зохион байгуулсан хөрөнгө орлогын мэдээлүүлийг хэрхэн гарган тайлагнах мэргэжил арга зүйн сургалтад 2 удаа цахимаар оролцсон мэдлэгээ дээшлүүлсэн. Түүнчлэн 2023 оны 2024 онд болон бүтэц орон тооны өөрчлөгдсөнтэй холбоотойгоор санхүү бүртгэл, хамралт орлогын хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогч албан тушаалд томилогдсон тул өөрийн болон өөрийн хамаарал бүхий этгээд, гэр бүлийн гишүүдэд орсон хөрөнгө, зээлтэй холбоотой мэдээллийг цахим системд бүрэн зөв тайлагнан, цаасаар баталгаажуулан хэлтсийн хариуцсан ажилтан Д.Гэрэлчимэгт хургуулсан.</p>	2024. 01.01	2024. 12.31
7	<p>Арга хэмжээ 2.3.7 Ашиг сонирхлын зөрчлөөс өөрийгөө урьдчилан сэргийлж ажиллах;</p>	Ашиг сонирхлын зөрчил гаргаагүй байх	Ашиг сонирхлын зөрчил гаргаагүй ажилласан.	<p>Ашиг сонирхлын зөрчил гаргаагүй байна.</p>	<p>Хэлтсийн удирдлага болон ХАСХОМ хариуцсан байцаагч болон аймгийн ЗДТГ-аарын Хууль зүйн хэлтэстэй хамтран зохион байгуулсан танхимын сургалт оролцож соён гэгээрүүлэх мэдээллийг цаг тухайд хүлээн авах, өөрийн ажлын байранд авлигын ашиг сонирхлоос антид байх сурталчилгааны хуудсыг байршуулан ажиллаа. Санхүү бүртгэл, хамралт орлогын хэлтсийн дарга болон ахлах нягтлан бодогчийн ажил үүргээ гүйцэтгэхдээ Төрийн албан хаагчийн тангарагтаа үнэнч ажиллаж, иргэд даатгуулагч нараас болон бусад хамааралтай этгээдэд ашиг сонирхлын зөрчил гаргаагүй ажилласан.</p>	2024. 01.01	2024. 12.31
8	<p>Арга хэмжээ 2.3.8 Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задрүүлэхгүй ажиллах</p>	Хувь хүний нууцын тухай хууль болон байгууллагын нууцын тухай хууль хэрэгжсэн байна.	Хувь хүний нууцын тухай хуулийг мөрдөж ажилласан	<p>Ажил олгогч, даатгуулагчдын эрх ашиг хамгаалагдсан байна.</p>	<p>Нийгмийн даатгалын мэдээллийн санд 770 шимтгэл төлөгч ажил олгогч, 17336 даатгуулагч болон 19850 тэтгэвэр, тэтгэмжийн авагчдын иргэний бүртгэлийн мэдээлэл болон ХХТАО, шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтыг бүртгэх, тайлагнах, нийгмийн даатгалын мэдээллийн санг бүрдүүлж ажилласан ба дээрх даатгуулагчтай холбоотой</p>	2024. 01.01	2024. 12.31

	Арга хэмжээ 2.3.9 Шинээр хэрэгжиж буй хуулийг хэрэгжүүлэх	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг хэрэгжүүлсэн байна.		Мөрдөж ажилласан байна.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ - ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр Засгийн газар-14, НДҮЗ-12, ХНХЯам-9, ХНХЯ болон ЭМЯам хамтран-4, ХНХЯам болон ГХЯам хамтран-1, ХНХЯам-Сангийн яам хамтран -1, НДЕГ-7, НДЕГ-Татварын ерөнхий газартай хамтран-1 нэмэлтээр ЗГ-3, НДҮЗ-2, ХНХЯам-1 нийт 55 батлагдсан заавар, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаа.					
9										

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАД ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ.

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
			Суурь түвшин	Эхний жил	Хүрэн түвшин /биелэлт/	Хүрэн түвшин /биелэлт/		
1	Арга хэмжээ1.2 Дээд шатны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан	Сургалтанд үр дүндтэй хамрагдах	Дээд шатны байгууллагын 9	Зохион байгуулагдсан сургалтанд бүрэн	НДЕГазар, аймгийн Төрийн Аудитын газар, Авлигатай тэмцэх газар, зохион байгуулсан “Нийгмийн даатгалын мэдээллийн цахим системийн сургалт”, төрийн үйлчилгээг цахимжуулж буй сургалт, ажил олгогчдод зориулсан сургагч багш бэлтгэх сургалт,			

	сургалтанд хамрагдах		Төрийн бус байгууллагын 5 хамрагдсан	хамрагдсан байна	Шилэн дансны шинэчлэл, аудитын мөрөөр хэрэгжүүлэх ажил, хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгийг зохистой зарцуулах, мэргэшүүлэх зэрэг мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн хийгээд мэргэжил арга зүйн зөвөлгөө авсан сургалтуудад цахимаар болон танхимаар хамрагдсан. Үүний үр дүнд нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, цаашид анхаарах асуудлыг хяналтандаа авах, үүний мөрөөр хэрэгжилтийг хэрхэн хангах талаар мэргэжил арга зүйн зөвөлгөө, мэдлэгийг авч ажилласан.	2024. 01.01	2024. 12.31
2	Арга хэмжээ2. Хууль тогтоомжийн өөрчлөлтүүдийн талаар мэдлэгээ тухай бүр дээшлүүлэх	Ажлын байранд шаардагдах хууль тогтоомж, эрхзүйн мэдлэгтэй байна.	Холбогдох хууль, дүрэм журмыг мөрдсөн байна.	Хуулийн хүрээнд ажил үүргээ гүйцэтгэсэн байна.	2024 хэрэгжиж буй Нийгмийн даатгалын багц хууль болон системийн шинэчлэлтэй холбоотой НДЕГ-аас өгч буй зөвлөмж, чиглэлүүдийг хяналтандаа авах, тэдгээрийн хэрэгжилт, хөгжүүлэлтийн талаарх мэдлэгээ дээшлүүлж үүний мөрөөр тайлант хугацааны турш ажил олгогч, даатгуулагч, иргэдэд сурталчлан ажилласан. Түүнчлэн нийгмийн даатгалын болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа явуулахдаа тайланд онд шинээр хэрэгжиж буй Засгийн газрын тогтоол, журмыг судлах, удирдлага болон дээд шатны байгууллагуудаас өгч буй чиглэл зөвлөмжийн мөрөөр байцаагч, ажилчид, даатгуулагчдад зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж ажилласан. Үүний үр дүнд Дээрх Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаа. Түүнчлэн нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад бэлтгэн, нийгмийн даатгалын байцаагчийн судалбал зохих хууль, тогтоомжийг жагсаалтын дагуу судлан мэдлэгээ улам бэхжүүлэх, дээшлүүлж ажилласан.	2024. 01.01	2024. 12.31


3	Арга хэмжээ3. Цахим мэдээллийн өөрчлөлтүүдийн талаарх мэдлэгээ тухай бүр дээшлүүлж ажиллах	Цахим мэдээллийг тухай бүр олж авч өөрийн ажилдаа хэрэгжүүлж мэдлэгээ дээшлүүлсэн байна.	Цахим мэдээллийг тухай бүр нь олж авч мэдээллийг шинэчлэн ажилласан.	Цахим хуудсанд мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн авч хэрэгжүүлж ажилласан байна.	Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн шинэ системийг нэвтрүүлж буй үед дээд газраас өгч буй сургалтуудад цаг тухайд нь хамрагдан цахим системийн талаарх өөрийн мэдлэгээ дээшлүүлэх, иргэд, даатгуулагч, байцаагч нарт сурталчлах, тайлбарлан таниулах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг тасралтгүйгээр гүйцэтгэн ажиллаа. Түүнчлэн нийгмийн даатгалын системийн "Зар мэдээ" цахим хаягнаас Ур ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг байнга авч ажиллж хэвшсэн. Үүний үр дүнд нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хүлээн авах, мэдээллийн санд бүртгэх, сайн дурын даатгуулагчийн гэрээг цахимаар байгуулах, тэтгэвэр, тэтгэмжийг цахимаар хянах зэрэг шинэчилсэн системийн бүртгэлийн талаарх цаг алдалгүй авч биелэлтийг ханган ажиллаа.	2024.01.01	2024.12.31
4	Арга хэмжээ4. Монгол бичиг, англи хэлний мэдлэгээ дээшлүүлж ажиллах	Монгол бичгийг зөв алдаагүй уншиж бичиж сурсан байх.	НДЕГ-аараас зохион байгуулсан анхан шатны сургалтанд бүрэн хамрагдсан.	Монгол бичиг, англи хэлний анхан шатны мэдлэгтэй болсон байна.	Монгол бичгийн талаарх өөрийн мэдлэгээ дээшлүүлэн, орчин үеийн техник, хэрэглээний программд монгол бичгээр бичих дунд шатны сургалтад хамрагдаж, цаашид суралцах, төрийн албыг монгол бичгээр хөглөхөд өөрийгөө бэлтгэж байна.	2024.01.01	2024.12.31

ТАЙЛАН БИЧСЭН:

САНХҮҮ БҮРТГЭЛ, ХАМРАЛТ ОРЛОГЫН

ХЭЛСТИЙН ДАРГА, АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ :

2024.12.06



/ Ц.БУЛГАНЧИМЭГ /